

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

(2022 оны эхний хагас жил)

2022.06.13

НЭГ. ЗОРИЛГО

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 56 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд туссан Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж хүргүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгөх, төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Засгийн газрын 2021 оны 374 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг зорилтот түвшин, шалгуур үзүүлэлттэй уялдуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж хүргүүлж байна.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 2 зорилтын хүрээнд 21 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтэд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт **59,5 хувь**, “**эрчимжүүлэх шаардлагатай**” гэж үнэллээ.

Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 21 арга хэмжээнээс 100 хувьтай 3, 90 хувьтай 1, 70 хувьтай 8, 50 хувьтай 3, 30 хувьтай 5, 0 хувьтай 1 арга хэмжээ байна.

Хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилт, арга хэмжээ тус бүрээр харуулбал:

№	Бодлогын зорилго, зорилт, арга хэмжээ	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хувь
Бүлэг 3.Эдийн засгийн бодлого				
Зорилт 2.5. Эрүүл баталгаат орчныг бий болгоно:				
1	Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх	Зураг төслийг батлуулж, барилга угсралтын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна.	Шилний үйлдвэрийн үндсэн түүхий эд болох цахиурын элсний ордын ТЭЗҮ-ийг 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн ЭБМЗ-ийн ТЭЗҮ хүлээн авах хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн.	0
2	Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны	Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулсан байна.	Энэхүү ажилд шаардагдах хөрөнгийг 2022 оны улсын төсөвт тусгах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн боловч тусгагдаагүй. "Геодези, зураг зүйн салбарт хамтран ажиллах тухай" Монгол, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд байр зүйн зураг зохиох чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг тусгаад байна.	30

	масштабтай байр зүйн зургаар зурагжуулах			
3	Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа барилга байгууламжийг паспортжуулан, насжилтыг тодорхойлж, цахим мэдээллийн нэгдсэн санд үнэлгээг оруулах	Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг аймаг, нийслэлд үргэлжлүүлэн хийнэ /405 барилга/.	2022 оны Нийслэлийн төсөвт барилга байгууламжийг паспортжуулах ажилд 560 сая төгрөг туссан бөгөөд энэ ажлыг гүйцэтгэх гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлыг Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар зохион байгуулж байна.	30
4	Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлэн хяналт тавих	Мониторингийн сүлжээний 3000 цэгт газрын төлөв байдал, чанарын судалгааг хийж, хөрсний хяналт-шинжилгээний улсын 1 лабораторийг Төвийн бүсэд байгуулсан байна.	Төв, баруун, зүүн бүсүүдэд лаборатори байгуулах ажлын санхүүжилтийг 2022 оны улсын төсөвт тусгах саналыг СЯ-нд хүргүүлсэн боловч хасагдсан. Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны үйл ажиллагааг цахим хэлбэрээр гүйцэтгэж, нийт 5630 тайлан цахим системээр баталгаажуулсан.	30
5	Хот, суурин газрын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох арга хэмжээний хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна.	2022 онд улсын төсвийн 7042.8 сая.төгрөгийн санхүүжилтээр УБ БЗД, Увс, Архангай, Говь-Алтай, Дорноговь, Сүхбаатар зэрэг аймгуудад усан сан, гүний худаг шинээр барих автоматжуулалтын ажлууд хийгдэж байна.	70
Бүлэг 6.Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого				
Зорилт 6.1.Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.				
7	“Дэнжийн мянга дэд төв”, “Дамбадаржаа дэд төв” төслийг хэрэгжүүлэх	Төслийн гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна.	Дамбадаржаа дэд төвийн зураг төсөл 95%, газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлт 60.5%, худалдан авах ажиллагаа 55.52%, инженерийн нарийвчилсан зураг төсөл 85.4%, барилгын ажил 24.5%-тай явагдаж байна.	50
8	АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг барих төслийг хэрэгжүүлэх	Төслийн гүйцэтгэл 15 хувьд хүрсэн байна.	Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилгын талбай дээрх газар шорооны ажлын явц 85%. Талбайн түр барилгын ажлууд 98%-тай, хашаажуулалт, түр зам гаргах ажил, гүний худаг гаргах ажил, түр цахилгаан хангамжийн ажил бүрэн хийгдэж дууссан.	70
9	Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд “Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл”-ийг хэрэгжүүлэх	Төслийн гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна.	Төслийн бэлтгэл ажил бүрэн хангагдаж, барилгажих талбайн газрыг бүрэн чөлөөлж, төслийг эхлүүлээд байна.	30
10	Төр-хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааны хүрээнд	Зураг төсөл, инженерийн бэлтгэл арга хэмжээг бүрэн	“Залуус 1” орон сууцны хорооллын ТЭЗҮ-ийн урьдчилсан судалгаа, архитектур	100

	30000 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх	дуусгаж, төр-хувийн хэвшлийн түншлэлээр бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн байна.	төлөвлөлтийн даалгавар, эх загвар зураг батлагдсан. Ус, дулаан, цахилгаан хангамжийн 4 багц ажлын гэрээ байгуулагдан, ажлыг эхлүүлсэн.	
11	Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна. -Үерийн 1.7 км далан /Сүхбаатар дүүрэг, 13, 14 дүгээр хороо/-г барьж ашиглалтад оруулсан байна. -Хайлаастын авто замын ус зайлуулах 1.5 км цутгамал төмөр бетон суваг /Чингэлтэй дүүрэг, 13 дугаар хороо/-ийг барьж ашиглалтад оруулсан байна.	1. Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг боловсруулж дуусган, магадлалаар хянуулж байна. 2. Үерийн 1.7 км далан /Сүхбаатар дүүрэг, 13, 14 дүгээр хороо/ барих ажил 100% дууссан. 3. Хайлаастын авто замын ус зайлуулах 1.5 км цутгамал төмөр бетон суваг /Чингэлтэй дүүрэг, 13 дугаар хороо/-ийг барих ажил 100% дууссан.	90
12	Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн 2475 айлын гадна инженерийн шугам сүлжээг барих	2475 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээ	"Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн хүрээнд гэр хорооллын 10 байршилд инженерийн шугам сүлжээний ажлууд хийгдэж байна. Тухайлбал: Баянзүрх дүүргийн 12-р хороо Амгалан орчмын дэд бүтцийн ажил 79%-тай байна.	70
13	Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд орлогод нийцсэн 740 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх	Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, төслийн зээлийн гэрээг байгуулж, санхүүжилтийг шийдвэрүүлж, төслийг эхлүүлсэн байна.	Төслийн санхүүжилтийг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг НИТХ-ын 2021.09.06-ны өдрийн 101 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголд тусгах санал боловсруулан, Улсын Их Хуралд өргөн бариад байна.	50
14	"Шинэ Зуунмод" хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн дэд бүтцийн зураг төслийг боловсруулсан байна.	Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2022.04.06-ны өдрийн 143-р тогтоолоор батлуулсан. Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээний зураг төсөл, ус хангамж, холбоо дохиоллын зураг төслийг боловсруулж, батлуулсан. Дулаан, цахилгаан хангамжийн зураг төслийг боловсруулж байна.	100
15	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд 11 аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих ажлыг	Төслийн гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна.	Архангай, Өвөрхангай, Булган, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий, Дорноговь, Дундговь аймгуудын цэвэрлэх байгууламж бүрэн баригдаж дууссан. Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангайн Хужирт сумын цэвэрлэх байгууламж 60-80%-ийн гүйцэтгэлтэй баригдаж байна.	100

	үргэлжлүүлэн хэрэгжүүлэх			
16	Аймгийн төв, суурин газрын 8 цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн хэрэгжилтийг 10 хувьд хүргэх /Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын төв болон Улаанбаатар хотын Багануур дүүрэг/	Төслийн гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна.	Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгийн цэвэрлэх байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын явц 70%, Дорнод аймгийнх 20%, Говь-Алтай аймгийнх 10%, УБ Багануур дүүргийнх 30%-тай байна.	30
17	Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга байгууламжийг барих ажлыг үе шаттай эхлүүлэх	Хэнтий аймгийн Хэрлэн, Цэнхэрмандал сумдын болон Баянхонгор аймгийн төвийн үерийн хамгаалалтын далан суваг барих ажил 70 хувьтай байна. Баян-Өлгий аймгийн төвийн үерийн хамгаалалтын далан сувгийн ажил 40 хувьтай байна.	Хэнтий аймгийн Хэрлэн сумын үерийн далангийн ажил 15%, Цэнхэрмандал сумынх 75,8%, Баянхонгор аймгийн төвийнх 100%, Баян-Өлгий аймгийн төвийн үерийн хамгаалалтын далан сувгийн ажил 47%-тай явагдаж байна.	70
18	Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн төвүүдийн хог хаягдлын менежментийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх	Төслийн хэрэгжилт 100 хувьд хүрсэн байна.	Говь-Алтай аймагт хог хаягдлын хяналттай шинэ төвлөрсөн цэгийн барилга -100%, Сүхбаатар аймагт хог хаягдлын хяналттай шинэ төвлөрсөн цэгийн барилга -100%, Дархан-Уул аймгийн төвд дахивар хүлээн авах цэгийн барилга -85%, Говь-Алтай, Сүхбаатар аймагт хог хаягдал нягтруулан тээвэрлэх байгууламж, автопүү ба дахивар хүлээн авах цэгийн барилга -20%-50%, Өвөрхангай аймагт автопүү, дахивар хүлээн авах цэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл-85% байна. Төслийн хэрэгжилт 77% байна.	70
19	Аймгуудын төвд түрээсийн орон сууц барих ажлыг хамтран зохион байгуулах	Түрээсийн орон сууц барих ажлыг үргэлжлүүлнэ.	2022 оны хагас жилийн байдлаар 12 аймгийн 13 суманд 1630 айлын түрээсийн орон сууцны санг бүрдүүлээд байна.	70
20	“Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 18 суманд инженерийн дэд бүтцийг барьж байгуулах	Төслийг 18 сумын төвд хэрэгжүүлнэ.	2022 онд 9 аймгийн 15 суманд дулаан, ус хангамж, ариутгах татуургын шугам, сүлжээ, барилга байгууламжийг барих ажлыг гүйцэтгэж байна.	50
21	Аймгуудад эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний төв магистраль шугамыг шинэчлэх, шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх арга	Барилга угсралтын ажлыг үе шаттайгаар гүйцэтгэсэн байна.	Нийт 22 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байгаагаас 21 төсөл арга хэмжээ дунджаар 40 хувийн гүйцэтгэлтэй, 1 арга хэмжээг 2022 оны 06-р сард эхлүүлээд байна.	70

	хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх			
22	Хангайн бүсийн төв Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын зарим орон сууцны барилгыг дахин төлөвлөлтөд оруулах /Арвайхээр, Хужирт, Хархорин сумдын гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах, шинэчлэх, Уянга, Бат-Өлзий сумдыг “Сумын хөгжил” арга хэмжээнд хамруулах/	“Сумын хөгжил” арга хэмжээнд 2 сумыг хамруулсан байна.	Өвөрхангай аймгийн Уянга, Бат-Өлзий, Хужирт сумдыг “Сумын хөгжил” арга хэмжээнд хамруулж, барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаад байна.	30
Хэрэгжилт				59,5%

2022 оны эхний хагас жилд дараах томоохон арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2022.04.06-ны өдрийн 143-р тогтоолоор;

Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дэх “Чингис хаан” шинэ нисэх онгоцны буудлыг түшиглэн 1000 га газарт Хөшигийн хөндийн Эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах асуудлыг УИХ-ын 2022.04.07-ны өдрийн 10 дугаар тогтоолоор;

Төрийн захиргааны зарим байгууллагын ажиллах нэгдсэн байрыг Төв аймгийн Хөшигийн хөндий рүү нүүлгэн шилжүүлэх асуудлыг Засгийн газрын 2022.03.09-ний өдрийн 98 дугаар тогтоолоор тус тус батлуулсан.

Засгийн газрын 2022.04.06-ны өдрийн 143-р тогтоолоор баталсан Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд “Орон сууц, олон нийт, худалдаа, үйлчилгээний бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” ажил, “Эдийн засгийн чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”, “Тээвэр, ложистикийн төвийн ТЭЗҮ, эхний ээлжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-ний ажлын явц 70 хувьтай байна. “Сургалт-Эрдэм шинжилгээ-Үйлдвэрлэлийн цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж байна. Ажлын явц 30%.

Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ, ус хангамж, холбоо дохиоллын зураг төслийг боловсруулж, батлуулсан. Дулаан, цахилгаан хангамж, эхний ээлжийн ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулж байна.

Дээрх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний болон инженерийн хангамжийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулахад 3,6 тэрбум төгрөгийн гэрээ байгуулагдан, ажлыг гүйцэтгэсэн байна.

Хэрэгжилт 0%-тай, тасарсан арга хэмжээ 1 байна. Үүнд:

Арга хэмжээ 3.7.1. “Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх”.

Зорилтот түвшин: Зураг төслийг батлуулж, барилга угсралтын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна.

Хэрэгжилт хангалтгүй, 30 хувьтай арга хэмжээ 5 байна. Үүнд:

1.Арга хэмжээ 3.7.2. “Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам, төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах”

Зорилтот түвшин: Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулсан байна.

2. Арга хэмжээ 3.7.3. Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа барилга байгууламжийг паспортжуулан, насжилтыг тодорхойлж, цахим мэдээллийн нэгдсэн санд үнэлгээг оруулах”

Зорилтот түвшин: Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг аймаг, нийслэлд үргэлжлүүлэн хийнэ /405 барилга/.

3. Арга хэмжээ 3.7.4. “Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлэн хяналт тавих”

Зорилтот түвшин: Мониторингийн сүлжээний 3000 цэгт газрын төлөв байдал, чанарын судалгааг хийж, хөрсний хяналт-шинжилгээний улсын 1 лабораторийг Төвийн бүсэд байгуулсан байна.

4. Арга хэмжээ 6.1.5. “Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд “Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл”-ийг хэрэгжүүлэх”

Зорилтот түвшин: Төслийн гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна.

5. Арга хэмжээ 6.2.4. “Аймгийн төв, суурин газрын 8 цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн хэрэгжилтийг 10 хувьд хүргэх /Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын төв болон Улаанбаатар хотын Багануур дүүрэг/”

Зорилтот түвшин: Төслийн гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна.

Хэрэгжилтийг эрчимжүүлэх, 50 хувьтай арга хэмжээ 3 байна. Үүнд:

1.Арга хэмжээ 6.1.1. “Дэнжийн мянга дэд төв”, “Дамбадаржаа дэд төв” төслийг хэрэгжүүлэх”

Зорилтот түвшин: Төслийн гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна.

2. Арга хэмжээ 6.1.12. Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд орлогод нийцсэн 740 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх

Зорилтот түвшин: Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, төслийн зээлийн гэрээг байгуулж, санхүүжилтийг шийдвэрүүлж, төслийг эхлүүлсэн байна.

3. Арга хэмжээ 6.2.9. “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 18 суманд инженерийн дэд бүтцийг барьж байгуулах”

Зорилтот түвшин: Төслийг 18 сумын төвд хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Их хурлын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 56 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд туссан Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 21 арга хэмжээний хэрэгжилтэд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт **59,5 хувь**, “**эрчимжүүлэх шаардлагатай**” гэж дүгнэж байна.

2022 оны эхний хагас жилд “Шинэ Зуунмод” хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн дэд бүтцийн зураг төслийг боловсруулах ажлыг шуурхай зохион байгуулж ажилласны үр дүнд төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх боломж бүрдсэн.

“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд туссан Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 21 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2022 оны эхний хагас жилийн байдлаар улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн нийт 68,8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Үүнээс : улсын төсвийн 3,3 тэрбум төгрөг; гадаадын зээл, тусламжийн 65,5 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байгаа нь дараах нөхцөл байдлаас шалтгаалсан гэж үзэж байна. Үүнд:

А. Хөрөнгө, санхүүжилт шийдэгдээгүйн улмаас тасарсан арга хэмжээ 5 байна. Үүнд:

- 1.Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх, /72,0 тэрбум төг-Орон нутгийн төсөв/
 - 2.Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25 000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулах, /24,0 тэр.төг-Улсын төсөв/
 - 3.Барилга байгууламжийг паспортжуулах, /405 барилга/. /820,0 сая.төг-Улсын төсөв/
 - 4.Мониторингийн сүлжээний 3000 цэгт газрын төлөв байдал, чанарын судалгааг хийж, хөрсний хяналт-шинжилгээний улсын 1 лабораторийг Төвийн бүсэд байгуулах. /92,0 сая төг-Улсын төсөв/
 - 5.“Дэнжийн мянга дэд төв”, “Дамбадаржаа дэд төв” төслийг хэрэгжүүлэх. /20,0 тэрбум төг-Орон нутгийн төсөв/.
- Нийт 117,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх шаардлагатай.

Б. Санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдсэн боловч зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ 4 байна. Үүнд:

1. Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд “Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл”-ийн хэрэгжилтийг 70 хувьд хүргэх,
2. Аймгийн төв, суурин газрын 8 цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн хэрэгжилтийг 10 хувьд хүргэх /Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын төв болон Улаанбаатар хотын Багануур дүүрэг/
3. “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 18 суманд инженерийн дэд бүтцийг барьж байгуулах,
4. Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороонд орлогод нийцсэн 740 айлын орон сууцны төслийг хэрэгжүүлэх.

Монгол Улсын хөгжлийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний санхүүжилтийн талаар: /тэрбум төг/

2022 оны эхний хагас жилд зарцуулсан санхүүжилт	Улсын төсөв	Нийт – 3,3 тэрбум төг /Шинэ 100мод -2,1тэр.төг, 1008төсөл - 1,2 тэр. төг/	68,8 тэрбум төгрөг
	Орон нутгийн төсөв	-	
	Гадаадын зээл, тусламж	Нийт – 65,5 тэрбум төг /Польш -3,8 сая евро, АХБ- 25,7 тэр.төг АНУ МССан-28,4 тэр.төг/	
	Бусад	-	

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүйн улмаас хэрэгжилт хангалтгүй 5 арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээс шийдвэрлүүлэх боломжийг судлан, санал боловсруулан танилцуулж, шийдвэрлүүлэхийг

Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Э.Ганхүү/, Бодлого, төлөвлөлтийн газар /Б.Гүнболд/, болон холбогдох газрын дарга нарт даалгах;

2. Монгол Улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд туссан хэрэгжилт хангалтгүй 0-50%-тай 9 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ авч, гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж, 2022 оны 3-р улиралд БХБСайдын Зөвлөлд эргэж танилцуулахыг бүх газар, хэлтсүүдэд үүрэг болгох;

3. Хөгжлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээ 3.7.3. Барилга байгууламжийг паспортжуулах ажлын хүрээнд аймаг, орон нутгийн нөөц бололцоог ашиглан хөрөнгө санхүүг шийдүүлэх замаар аймаг, орон нутаг болон холбогдох газруудтай хамтран энэхүү арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гантулга/-т даалгах;

4. Хөгжлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээ 3.7.4. “Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг бий болгож, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлэн хяналт тавих” ажлын хүрээнд бэлчээрийн хөрс хамгаалах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр хөдөө, орон нутгийн малчид бүлэг байгуулан идэвхтэй ажиллаж байгаа сайн туршлага байгаа тул бэлчээр ашиглагчдын холбоотой хамтран ажиллах, мэдээлэл солилцох, мэдээллийг тайланд тусгаж байхыг Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Баярбат/-т даалгах;

5. Цаашид яамны бүх газар, хэлтсүүд төлөвлөлтөө сайжруулан, Монгол Улсын хөгжлийн дараа жилүүдийн төлөвлөгөөг боловсруулахдаа арга хэмжээний зорилтот түвшинг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдийн тухайн жилийн зорилтот түвшинтэй уялдуулан оновчтой, зөв тодорхойлох, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр, санхүү, хөрөнгийн тооцоог үндэслэлтэй, бодит, зөв гаргаж хэвших, яамны газар, хэлтсүүд мэдээллээ солилцон хамтран ажиллах;

6. “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд санхүү, эдийн засаг болон төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд анхаарч, улсын төсөв, бусад эх үүсвэрээс шийдвэрлэн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжоор хангах шаардлагатай байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗАР